



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 11420.

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.3.2 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар өмчлөх эрхээсээ татгалзаж орон сууцны зориулалтаар газар эзэмших хүсэлт гаргасан “Гэрэлт гэгээ наран” ХХК /5818842/-д Жаргалант сумын Магсаржав багийн 5 дугаар гудамжны 08 а, 08 б тоотод байрлах газруудыг нэгтгэн 1951.0 метр квадрат, хаягийг Амарсанаагийн 5 дугаар гудамжны 520 тоот болгон орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар, 217 метр квадрат газрыг Адилбишийн Пүрэв-Очир /ПЮ85062672/-д хаягийг Амарсанаагийн 5 дугаар гудамжны 520 тоот болгон худалдаа, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

